

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН МАТЕРИАЛ

2026

# АГЛУЛГА

Хурлын зар

Хурлаар хэлэлцэх асуудал

Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт

Ээлжит хурал хуралдуулах шийдвэр

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг

Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой материал

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүд

Саналын хуудасны загвар

Тэмдэглэл

# “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар

## “БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“БиДиСЕК” ҮЦК ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 сарын 29-ний өдөр 10:00 цагт <http://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2026 оны 04 сарын 02  
Цахим хурал зохион байгуулах холбоос: <https://agm.mn/>

### ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД:

- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах
- Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах

Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичгийг 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөс 2026 оны 04-р сарын 28-ны өдөр хүртэл ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд ирж танилцах, эсвэл харьяалагдах Үнэт Цаасны Компаниас авч танилцах боломжтой.

Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид саналаа бүртгэлтэй брокер, дилерийн компаниар дамжуулах, компанийн байранд биеэр ирж цаасаар өгөх боломжтой. Урьдчилан санал авах сүүлчийн хугацааг 2026 оны 04 сарын 28-ны өдрийн 15:00 цагаар тасалбар болгоно.

Аж ахуй нэгжийг төлөөлөн хуралд орлох хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл урьдчилан хурал зохион байгуулах комисстой холбогдон тодруулага, мэдээлэл авна уу.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын Өргөн Чөлөө 27/1  
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байр  
Утас: 75551919, 99013089

Электрон шуудангийн хаяг: [info@bdsec.mn](mailto:info@bdsec.mn), [t.shuudertsetseg@bdsec.mn](mailto:t.shuudertsetseg@bdsec.mn)

### ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

## ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах
2. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан
3. ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авах хуудас
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл

Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичгийг 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөс 2026 оны 04 -р сарын 28-ны өдөр хүртэл ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд ирж танилцах, эсвэл харьяалагдах Үнэт Цаасны Компаниас авч танилцах боломжтой.

### ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР



## “БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 11-ний өдөр

№ 05/26

Улаанбаатар хот

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх заалт, 71 дүгээр 71.1, 71.3, 71.4 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалтууд болон Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 03-р сарын 11-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “БидиСЕК ҮЦК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4 сарын 29-ний өдөр 10 цагт <https://agm.mn/> холбоосоор цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
  - a) Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах,
  - b) Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах,
  - c) Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
  - d) Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох,
  - e) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах,
  - f) Аудитын байгууллагыг сонгох.
3. Хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2026 оны 03 сарын 13-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсүгэй.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин,

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР



орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компанийн цахим хуудсаар дамжуулан 2026 оны 03 сарын 16-ны өдөр нийтэд мэдээлж, уг зарыг 2026 оны 03 сарын 31-ний өдөр дахин нийтэд мэдээлсүгэй.

5. Ногдол ашиг авах болон хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 сарын 02 өдрөөр тогтоосугай.
6. Хурлын зарын загвар, хэлэлцэх асуудлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
7. Хурлын дэгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
8. Хурлын танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай.
9. Хурлын саналын хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
10. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2026 оны 03 сарын 20-ний өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлсүгэй. Хурлын материалтай ажлын өдрийн 09:00-17:00 цагийн хооронд танилцах боломж бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал болон Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
11. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж Компанийн өөрийн байранд урьдчилсан саналын хуудсыг хүлээн авах ба саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15:00 цаг байна.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Т.Шүүдэрцэцэг, гишүүнээр М.Оюунсүвд нарыг тус тус томилсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга Д.Даянбилгүүн, тооллогын комиссын даргаар "БидиСЕК ҮЦК" ХК-ийн Хөрөнгө оруулалтын албаны захирал С.Дөлгөөн, гишүүнээр "БидиСЕК ҮЦК" ХК-ийн мэргэжилтэн Б.Хулан нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

/Д.ДАЯНБИЛГҮҮН/

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

<b>1. Хурлын ирц бүртгэл</b>	
1.1. Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг)	09:50-10:00
1.2. Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг)	10:00-10:05
<b>2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хурлын дарга нээх</b>	10:05-10:10
<b>3. Хэлэлцэх асуудлуудыг төлөвлөгөөний дагуу танилцуулах</b>	
1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах	10:10-10:30
2. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах	10:30-10:40
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах	10:40-10:50
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох	10:50-11:10
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах	11:10-11:20
<b>4. Хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой асуулт хариулт</b>	11:20-11:30
<b>5. Саналын хуудсыг бөглөх, санал хураалт</b>	11:30-11:40
<b>6. Хурлын завсарлага</b>	11:40-11:50
<b>7. Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах, батлуулах</b>	11:50-11:55
<b>8. Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах</b>	11:55-12:00
<b>9. Хурлыг хаах (хурлын дарга)</b>	12:00-12:05

## ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС


# 2025

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

---

# БРОКЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## Арилжаанд эзлэх хувь



2025 оны  
"БиДиСЕК ҮЦК" ХК-ийн  
нийт арилжааны дүн:

134

тэрбум төгрөг

"БиДиСЕК ҮЦК" ХК нь 2025 онд Монголын хөрөнгийн бирж дээр нийт 1.67 их наяд төгрөгийн арилжаа хийгдсэний 8% буюу 134 тэрбум төгрөгийн арилжааг хийж гүйцэтгэсэн. Энэхүү үзүүлэлтээр бид нийт 52 үнэт цаасны компаниас дөрөвдүгээрт эрэмбэлэгдэж байна.

**ЗАСГИЙН ГАЗРЫН  
ҮНЭТ ЦААС:**

42.4

тэрбум төгрөг

**НИЙТ  
ЗАХИАЛГЫН ТОО:**

54,233

**ХАРИЛЦАГЧДЫН  
ТОО:**

+3,021

# БРОКЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## Уул уурхайн биржийн бүтээгдэхүүний арилжаа

БиДиСЕК ҮЦК ХК нь 2025 оны 10-р сард уул уурхайн биржийн анхны арилжаагаа хийсэн. Ийнхүү гурван сарын хугацаанд нийт 71.4 сая ам долларын арилжаа хийж гүйцэтгэлээ.

### АРИЛЖААНЫ ДҮН

# 71.4

САЯ \$

### АРИЛЖААНЫ ТОО

# 10

### ХАРИЛЦАГЧДЫН ТОО


# 55

Уул уурхайн бүтээгдэхүүний бирж дээр зөвшөөрөл авсан 14 брокер байгаагаас идэвхитэй арилжаа хийж буй гурван компани байна. Үүнээс БиДиСЕК ҮЦК ХК нь арилжааны дүнгээрээ тэргүүлж МХБ-ийн дараа хоёрдугаарт эрэмбэлэгдэж байна.

### “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн УУББА-ны идэвхи

Нүүрс

2025 он



■ БиДиСЕК ■ Бусад ■ МХБ

Төмөр

2025 он



■ БиДиСЕК ■ МХБ

# АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД

BOND ON  
INTERNATIONAL  
MARKET

**200**  
MILLION \$

ISSUER:



Олон улсаас татан  
төвлөрүүлсэн нийт  
дүн:

**200**

сая ам доллар

Placing agent:  國泰君安國際  
GUOTAI JUNAN INTERNATIONAL



Татан төвлөрүүлсэн дүн:  
6 тэрбум ₮



Татан төвлөрүүлсэн дүн:  
1.5 тэрбум ₮



Татан төвлөрүүлсэн дүн:  
6.5 тэрбум ₮



Дорнын их гэгээ ХХК

Татан төвлөрүүлсэн дүн:  
7.5 тэрбум ₮

Дотоодод татан  
төвлөрүүлсэн нийт дүн:

**21.3**

тэрбум төгрөг

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

## Зөвлөгөө өгөх ажлын хүрээнд

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал авах ажиллагааны онцлог, зохион байгуулалтад анхаарах зүйлсийн талаар зөвлөмж өгөх
2. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараах зарын загварыг боловсруулахад оролцох
3. Санал өгөх зааварчилгааг бэлтгэх
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргах тогтоол шийдвэрийн төслийг боловсруулахад оролцох
5. Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуулт тодруулгуудад хариулахад идэвхтэй оролцох



"БидиСЕК ҮЦК" ХК



"АПУ" ХК



"ХААН Банк" ХК



"Монголын Хөрөнгийн Бирж" ХК




"Эрдэнэ Ресурс Девелопмент" ХК



"Таван толгой" ХК



"Э-Транс ложистикс" ХК



"МММон" ХХК



"Инновэйшн инвестмент" ХК



"Баянтээг" ХК



"Монложистик холдинг" ХК




"ГазҮйлдвэрар Шим" ХК

## ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН КОМПАНИЙН ТОО:

14



"Эм Жи Эл Акуа" ХК



"Зэс эрдэнийн хувь" ХХК

# ГАДААД ХАРИЛЦАА

## ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Олон улсад зохиогдож буй эвент, форумд оролцож хөрөнгийн зах зээлийн оролцогч байгууллагууд болон хөрөнгө оруулагчидтай уулзалтуудыг зохион байгуулах замаар дараах чиглэлд гадаад хамтын ажиллагааг тэлэхийг зорисон:

- ✓ Монголын топ ХК-иудыг АНУ-ын OTC market дээр гаргах
- ✓ Институциональ харилцагчдын базыг нэмэгдүүлэх
- ✓ Монголын топ компаниудын үнэт цаасыг олон улсын бирж дээр list хийх

### MONGOLIA INVESTMENT FORUMS

New York

April, 2025

Singapore

November, 2025

London

October, 2025

### MONGOLIA BUSINESS FORUM

Japan

November, 2025

## СУДАЛГААНЫ АЖИЛ

1

### INVESTMENT BLUEBOOK

Хагас жил тутам бэлтгэн хүргэдэг макро эдийн засаг болон хөрөнгийн зах зээлийн тойм бүхий цогц судалгааг 2 удаа хийж гүйцэтгэсэн.

### БАНКНЫ САЛБАР

Улирал тутам бэлтгэн хүргэдэг банкны салбарын судалгаа, арилжааны банкнуудын тайлангийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

2

### ДАТАБАЗЫН ТЭЛЭЛТ

Макро эдийн засгийн датабаз бүрдүүлэлт, банкны салбарын тайлан нэгтгэл, болон МХБ-ийн I ангилалын компаниудын тайлан нэгтгэл, датабаз бүрдүүлэлтийг гүйцэтгэсэн.

3

### ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭ

Долоо хоног бүр эдийн засаг, хөрөнгийн зах зээлтэй холбоотой мэдээ мэдээлэл, арилжааны тайланг харилцагчдад хүргэн ажилласан.

4

# Хараат бус аудиторын дүгнэлт



Хаяг: JS Tower 10-р давхар - 1002 тоот - Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нарны зам  
Улаанбаатар хот, Монгол улс

Утас:(976) 7013 1770  
Факс:(976) 7014 1770

Огноо: 2026.02.24

№ 26/04.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### "БИ ДИ СЕК ҮЦК" ХК-ийн УДИРИДЛАГАД

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Бид "Би Дек Сек ҮЦК" ХК (Компани гэх) 2025 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 9-30 хүртэлх хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

#### Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд томоохон хэмжээний аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

# Хараат бус аудиторын дүгнэлт

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа, тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах, компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

## Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримталдаг. Түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоох явдлууд багтсан байж болно.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцсан.

## Номинал дансны талаар

"Би Ди СеК ҮЦК" ХК нь өөрийн нэр дээр Голомт банкн дах 1105057130 тоот төгрөгийн данс, 1105391344 тоот ам. долларын данс, Худалдаа хөгжлийн банкн дах 452644001 тоот ам.долларын, 452643141 тоот төгрөгийн, Богд банкнд дах 816001183 тоот, Төрийн банк дах 343100276403 тоот төгрөгийн, Тээвэр хөгжлийн банк дах 90000109635 тоот, 9000092505 тоот төгрөгийн дансаар тус тус дамжуулан өөрийн харилцагчдын МХБ-н арилжааны хэлцлээс үүдэлтэй төлбөр тооцоог валют тус бүрээр ялган гүйцэтгэсэн байна.

# Хараат бус аудиторын дүгнэлт

Ингэхдээ Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-н 6.2.8. болон 6.2.9. шаардлагуудыг тус тус ханган ажиллаж, холбогдох хууль тогтоомжид заасан зохицуулалтыг мөрдөн ажиллаж байгаа нь гүйлгээний баримт, харилцагчийн арилжааны захиалгын гэрээ зэрэг анхан шатны баримтуудаар нотлогдож байна.

Тус журмын 6.2.5.-д заасны дагуу компани нь харилцагчийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлан, балансын гадуур бүртгэж, өөрийн эргэлтийн хөрөнгө болон, өөрийн хөрөнгийн зохист харьцаанд хамааруулан тооцдоггүй нь компанийн санхүүгийн байдлын тайлангаас харагдаж байна.

Харилцагчдын нэр дээр хийгдсэн орлого болон зарлага, арилжааны хэлцэлтэй холбоотой мөнгөн гүйлгээний мэдээллийг дэлгэрэнгүй хөтөлж, бүртгэлд үнэн зөв тусгасан бөгөөд холбогдох зохицуулалтын хүрээнд харилцагчдын гүйлгээтэй холбоотой дэлгэрэнгүй тайланг сар тус бүрээр гарган, зохицуулагч байгууллагуудад хүргэн ажилласан байна.

Бид аудитын горимын дагуу дээрх арилжааны банкинд байрших номинал дансанд аудитын горимын дагуу тулган баталгаажуулалтыг хийхэд ямар нэгэн алдаа зөрчил гараагүй болно.

Компани нь "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай" хуулийн 4.1.-т заасан "Мэдээлэх үүрэгтэй этгээд"-ийн хүлээсэн үүргийн хүрээнд номинал дансаар дамжин харилцагчдын дансанд хийгдсэн их дүнтэй гүйлгээний мэдээллийг Монгол банк болон Санхүүгийн Зохицуулах Хороонд тухай бүр болон улирал тутамд тогтмол цахим болон цаасан хэлбэрээр тайланг хүргүүлэн ажилласан байна.

"Би Ди Сек ҮЦК" ХК-ний харилцагчдын арилжааны төлбөр тооцоотой холбоотой мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, удирдах зорилго бүхий номинал дансны харилцагчийн мөнгөн гүйлгээний тайланг банкны хуулга болон анхан шатны баримт, мөнгөн хөрөнгө дамжсан данс бүрээр нь тулган шалгахад Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам", байгууллагын "Харилцагчийн мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоо, гүйлгээний журам" болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэн зөв хөтөлсөн байна.

## Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль" -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Би Ди Сек ҮЦК" ХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

  
"Пантер Мидланд Аудит" ХХК  
Гүйцэтгэх захирал Ц. Алтанцэцэг  
1118261832  
9103014 & CB71954

# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт:

Үзүүлэлт ХӨРӨНГӨ	12/31/2024	12/31/2025
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,965,040,324	7,072,288,539
Санхүүгийн хөрөнгө	5,069,044,414	7,626,180,759
Дансны авлага	2,775,600,426	3,123,767,838
Эргэлтийн бус хөрөнгө	4,456,117,912	4,303,293,868
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>40,981,430,601</b>	<b>54,840,990,294</b>
Өр төлбөр	19,525,735,151	25,383,144,682
Эздийн өмч	21,455,695,450	29,457,845,612

Орлогын тайлангийн үзүүлэлт:

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31 Гүйцэтгэл
<b>Нийт орлого</b>	<b>14,689,264,532</b>	<b>17,739,496,556</b>
ҮА-ны орлого :	11,969,287,141	15,094,638,886
Брокерийн орлого	3,831,046,969	528,675,282
Андеррайтерийн орлого	2,036,200,000	1,551,000,000
ХОЗҮ ний орлого	209,398,000	68,500,000
Диллерийн үйл ажиллагааны орлого:		
Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	1,395,185,761	6,967,844,203
Үнэт цаасны тэгшитгэлийн олз	4,497,456,411	5,978,619,401
<b>Бусад орлого :</b>	<b>2,719,977,391</b>	<b>2,644,857,670</b>
Бондын хүүгийн орлого	1,311,953,271	751,609,060
Ногдол ашгийн орлого	1,025,870,120	1,095,014,183
Банкны хүүгийн орлого	382,154,000	798,234,427
<b>Нийт зардал</b>	<b>7,827,607,653</b>	<b>7,165,409,936</b>
<b>Борлуулалт,маркетингийн зардал :</b>	<b>1,325,023,548</b>	<b>1,226,319,042</b>
Арилжааны шимтгэлийн зардал	1,244,742,111	1,119,279,397
Зохицуулагч байгууллагын шимтгэл хураамж	32,281,437	81,039,645
Бусад зардал	48,000,000	26,000,000
<b>Ерөнхий ба удирдлагын зардал :</b>	<b>3,995,498,398</b>	<b>3,925,402,495</b>
Цалин хөлс,НДШ, шагнал урамшуулал	1,907,200,860	2,476,899,661
Мэргэжлийн ажил үйлчилгээний хөлс	1,195,437,652	235,767,810
Томилолт/ Гадаад,дотоод/	117,690,144	296,192,645
Уулзалт хүлээн авалт	49,440,499	84,385,337
Сургалтын зардал	10,091,700	52,965,532
Бусад	715,637,543	779,191,510
<b>Санхүүгийн зардал :</b>	<b>2,507,085,707</b>	<b>2,013,688,400</b>
Зээлийн хүүгийн зардал	2,472,693,438	2,013,100,571
Бусад санхүүгийн зардал	34,392,269	587,829
Валютын ханшийн зөрүүгийн гарз / \$1 = 3,700₮/	121,384,772	828,506,472
<b>ААНОАТ зардал</b>	<b>199,633,218</b>	<b>515,409,829</b>
<b>Тайлант үеийн ашиг алдагдал</b>	<b>6,540,638,889</b>	<b>9,230,170,319</b>

# КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙГДСЭН ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2025 онд Монголын хөрөнгийн бирж дээр нийт 1.67 их наяд төгрөгийн арилжаа хийгдсэний 8% буюу 134 тэрбум төгрөгийн арилжааг хийж гүйцэтгэсэн. Энэхүү үзүүлэлтээр бид нийт 52 үнэт цаасны компаниас дөрөвдүгээрт эрэмбэлэгдэж байна.

Мөн Сингапурын хөрөнгийн бирж дээр бүртгэгдсэн “Төрийн Банк” ХК – ийн ОУ-ын 200 сая ам.долларын дүнтэй хаалттай бондын арилжааг зохион байгуулсан.

Санхүүгийн Зохицуулах Хорооны шаардлагыг хангасны дагуу үнэт цаасны номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан.

Уул уурхайн биржийн арилжааг эхлүүлэн 3 сарын хугацаанд нийт 260 тэрбум төгрөгний арилжааг хийлээ.

2025 онд зах зээлд аймаг, нийслэлийн бонд гараагүй бөгөөд 3 компанийн бонд шинээр гарч арилжаалагдсан нь уг хугацаанд нээлттэй бондын нийлүүлэлт сул байсныг харуулж байна. Манай компанийн хувьд “Биржийн бус зах зээлд” нийт 4 бондыг санал болгон гаргах ажиллагаанд андеррайтераар ажилласан. Тодруулбал, “Амила цэцэрлэг” БСБ-ийн бондын хүрээнд 6 тэрбум төгрөг, “Цогц зээл ББСБ” ХХК-ийн бондын хүрээнд 3.5 тэрбум төгрөг, “Дорнын их гэгээ” ХХК-ийн бондын хүрээнд 7.5 тэрбум төгрөг, “Таун Констракшн” ХХК-ийн бондын хүрээнд 6.5 тэрбум төгрөгийг тус тус амжилттай татан төвлөрүүлсэн байна.

2025 оны цэвэр ашиг 8.2 тэрбум гэж төлөвлөж байснаас гүйцэтгэлээр 9.2 тэрбум төгрөгт хүрч 12%-иар төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн. Энэ нь 2024 оны ашгаас 41%-ийн өсөлтийг үзүүлсэн байна. Ашигт ажиллагааны голлох үзүүлэлтийг Үнэт цаасны арилжааны цэвэр орлого 147%-ийн биелэлттэйгээр бүрдүүлж байна. Ийнхүү бид санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг үндэслэн 2025 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас нэгж хувьцаандаа 141.75₮ нийт ₮1,941,236,280.48-н ногдол ашиг хувиарлахаар шийдвэрлэсэн болно.

Иймд “БиДиСЕК ҮЦК” ХК нь 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хангалттай хэмээн Төлөөлөн Удирдах Зөвлөл дүгнэлээ.

# НОГДОЛ АШИГ ТАРААХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ШИЙДВЭР



## “БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 16-ны өдөр

№ 03/26

Улаанбаатар хот

### Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь заалт, Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02-р сарын 16-ний өдрийн санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “БидиСЕК ҮЦК” ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнг харгалзан хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 141.75 төгрөг, нийт 1,941,236,280.48 төгрөгийн ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Ногдол ашгийг 2026 оны 04 сарын 30-ны дотор “ҮЦТХТ” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд шилжүүлсүгэй.
4. “БидиСЕК ҮЦК” ХК-ийн 2025 оны ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тарааж олгохыг Гүйцэтгэх захирал (Б. Лхагвадорж)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

# ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

## ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



### 1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Данзан Даянбилгүүн
Иргэний харьяалал:	Монгол
Төрсөн он сар:	1976 оны 06 сарын 10

### 2. Боловсролын талаар

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Бизнесийн удирдлага, Магистрт	2003-2005
Европ хэлний дээд сургууль	1994-1998

### 3. Ажлын туршлага

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Ерөнхийлөгч	2022 оны 11 сараас
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Гүйцэтгэх захирал	1999-2022.11
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн салбарын менежер	1997-1999
Улсын Их Хурлын Тамгын газрын гишүүний орон тооны ажилтан	1995-1997
Эдийн Тэнгэр Банк – Оператор, нягтлан бодогч	1994-1995
“Юнизо” ХХК менежер	1993-1994

# ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

## ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



### 1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Бүрэнмэнд Лхагвадорж
Иргэний харьяалал:	Монгол
Төрсөн он сар:	1976 оны 02 сарын 04

### 2. Боловсролын талаар

Монгол улсын их сургууль Нефтийн инженер	1993-1997
---	-----------

### 3. Ажлын туршлага

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Гүйцэтгэх захирал	2022 оны 11 сараас
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Тэргүүн дэд захирал	1999-2022.11 сар

## ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



### 1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Uluc Bingol
Иргэний харьяалал:	Турк
Төрсөн он сар:	1986 оны 08 сарын 27

### 2. Боловсролын талаар

London Business School MSc in Finance	2011-2012
Кос Их Сургууль, Турк BSc in Industrial Engineering	2004-2008

### 3. Ажлын туршлага

Импера Капитал, Турк Дэд захирал	2012 оноос одоог хүртэл
Garanti Bank, Турк Эрсдэлийн ахлах шинжээч	2008-2011

# ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

## ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



### 1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Одгийв Уранбайгал
Иргэний харьяалал:	Монгол
Төрсөн он сар:	1985 оны 05 сарын 28

### 2. Боловсролын талаар

Санхүү эдийн засгийн их сургууль Санхүүгийн удирдлага, Магистр	2012-2016
Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль Бизнесийн удирдлага, Бакалавр	2008-2011

### 3. Ажлын туршлага

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Back Office албаны захирал	2022 оноос одоог хүртэл
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн харилцагчийн албаны менежер	2016-2022
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Back Office албаны менежер	2012-2016
“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн харилцагчийн алба, брокер	2009-2012

# ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

## ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



### 1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Andrew Brown
Иргэний харьяалал:	United States of America
Төрсөн он сар:	1983 оны 01 сарын 21

### 2. Боловсролын талаар

The George Washington University <b>MA, International Trade and Investment Policy</b>	2005-2007
The Ohio State University Fisher College of Business <b>BSBA, International Business</b>	2001-2005

### 3. Ажлын туршлага

Founder and Managing Partner at Canmore Capital	2022 оны 11 сараас одоог хүртэл
President at Delphos	2007-2022.11 сар
Board Member at Delphos	2005-2007
Managing Director, Global Head of Business Development at Delphos	2020.06-2021.05
Director at Delphos	2015.09-2020.06
Vice President at Delphos	2011.06-2015.08
Associate at Delphos	2008.05-2011.07
Financial analyst at Delphos	2006.02-2008.05

# ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

## ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



### 1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Hitoshi Tani
Иргэний харьяалал:	Япон
Төрсөн он сар:	1954 оны 12 сарын 20

### 2. Ажлын туршлага

Sanaa EХE Группын  
Ерөнхийлөгч

## ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



### 1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Баттогтох Энхбаяр
Иргэний харьяалал:	Монгол
Төрсөн он сар:	1980 оны 02 сарын 15

### 2. Боловсролын талаар

Хитоцубашигийн Их Сургууль , Япон Эдийн засаг, Магистр	2004-2006
Хитоцубашигийн Их Сургууль , Япон Эдийн засаг, Бакалавр	2000-2004
Монгол Улсын Их Сургууль Эдийн засаг, Бакалавр	1997-1999

### 3. Ажлын туршлага

Sanaa EХE ХХК-ийн Гүйцэтгэх захирал	2009 оноос одоог хүртэл
Гадаадын хөрөнгө оруулалттай том оврын Цахилгаан Станцын төсөл, Зөвлөх	2014-2018
Deutsche Bank, Global Markets, Токиогийн хөрөнгийн бирж дээрх хувьцааны багцийн арилжаа хариуцсан трэйдр, дилер	2005-2008

# ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

## ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



### 1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Дарамранз Амгаланбаяр
Иргэний харьяалал:	Монгол
Төрсөн он сар:	1975 оны 12 сарын 22

### 2. Боловсролын талаар

Монгол Улсын Их Сургууль  
Эдийн засагч, Бакалавр

### 3. Ажлын туршлага

МСМ Группийн Захиргааны мэргэжилтэн

## ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



### 1. Ерөнхий мэдээлэл

Овог нэр:	Мөнхжаргал Туяа
Иргэний харьяалал:	Монгол
Төрсөн он сар:	1976 оны 07 сарын 28

### 2. Боловсролын талаар

Жонс Хопкинсийн их сургууль	2019-2023
Санхүү эдийн засгийн их сургууль	2014-2018
Хүний нөөцийн удирдлага, Магистр	
Монгол улсын их сургууль	
Олон улсын харилцаа, Бакалавр	2000-2002

### 3. Ажлын туршлага

“Шилдэг сургууль”-ийн ТУЗ-ийн дарга	2014-Одоог хүртэл
“EDEX Mongolia”-ийн Гүйцэтгэх захирал, Үүсгэн байгуулагч	2001-Одоог хүртэл
“EDEXMN” ХХК-ийн хувьцаа эзэмшигч	2007-Одоог хүртэл

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД

## “БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 29-ний өдөр

№ 01/26

Улаанбаатар хот

### Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт болон 2026 оны 04 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн  
**ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**

**/Д. ДАЯНБИЛГҮҮН/**

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД

## “БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 29-ний өдөр

№ 02/26

Улаанбаатар хот

### Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.13 дэх заалт болон 2026 оны 04-рсарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн  
**ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг хавсралт №1 – ийн дагуу баталсугай.
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

**ХУРЛЫН ДАРГА:**

**Д.ДАЯНБИЛГҮҮН**

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД

## “БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 29-ний өдөр

№ 03/26

Улаанбаатар хот

### Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7. дэх заалт болон 2026 оны 04-р сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд олонхын санал авсан:

Ердийн гишүүдэд:

1. Данзан **ДАЯНБИЛГҮҮН**
2. Бүрэнмэнд **ЛХАГВАДОРЖ**
3. Одгийв **УРАНБАЙГАЛ**
4. **УЛУЧ** Бингол

Хараат бус гишүүдэд:

1. ХИТОШИ Тани
2. Дарамранз **АМГАЛАНБАЯР**
3. Баяртогтох **ЭНХБАЯР**
4. Мөнхжаргал **ТУЯА**
5. **АНДРЕВ** БРОВН

нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгосугай

**ХУРЛЫН ДАРГА:**

**Д.ДАЯНБИЛГҮҮН**

# САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 05/26 дугаар тогтоолын "Хавсралт-4"

## "БиДиСЕК ҮЦК" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр.....  
Регистрийн дугаар .....  
Хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн дугаар .....  
Эзэмшиж буй хувьцааны төрөл ..... Тоо .....

Бүртгэсэн / Брокер диллерийн компани / .....

"БиДиСЕК ҮЦК" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цагт Улаанбаатар хотод цахим хэлбэрээр зохион байгуулагдах болно.

Дараах хэлэлцэх асуудлуудыг ЕРДИЙН АРГААР санал хураана.

Ердийн аргаар саналаа өгөхөд асуудал бүрээр "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" аль нь болохыг тэмдэглэнэ.

№	Хэлэлцэх асуудлын нэр	Санал авах арга	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1.	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах	Ердийн	Тогтоол №01/26	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
2.	2026 оны ТУЗ-ийн төсөв батлах		Тогтоол №02/26	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

Брокер ..... /Гарын үсэг/

/ тэмдэг /

Хувьцаа Эзэмшигч ..... /Гарын үсэг/

2026 он ... сарын ... өдөр

Саналын хуудсын хүчинтэйд тооцон тоолсон Тооллогын Комиссын дарга .....

Тооллогын Комиссын Гишүүн .....

Хүчингүйд тооцон бол шалтгаан .....

.....

.....

# САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 05/26 дугаар тогтоолын "Хаесралт-4"

## "БиДиСЕК ҮЦК" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр.....  
Регистерийн дугаар .....  
Хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн дугаар .....  
Эзэмшиж буй хувьцааны төрөл ..... тоо .....  
Кумулятив хувьцааны тоо: .....  
Бүртгэсэн /Брокер диллерийн компани/ .....

"БиДиСЕК ҮЦК" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цагт Улаанбаатар хотод цахим хэлбэрээр зохион байгуулагдах болно.

**Дараах хэлэлцэх асуудлуудыг КУМУЛЯТИВ АРГААР санал хураана**  
Кумулятив саналын тоо нь таны эзэмшиж байгаа энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

Жишээ нь: Та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл нийт  $100 \times 9 = 900$  кумулятив саналын эрхтэй болно. Та нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамваран өөрийн сонгосон нэг эсвэл хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй

3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох				
ТУЗ-ийн ердийн гишүүн:	Санал авах арга	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Нэр дэвшигчид өгөх саналын тоо	
1. Данзан ДАЯНБИЛГҮҮН	Кумулятив	Тогтоол №03/26		
2. Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ				
3. УЛУЧ Бингол				
4. Одгийв УРАНБАЙГАЛ				
ТУЗ-ийн хараат бус гишүүн:				Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1. ХИТОШИ Тани				
2. Баяртогтох ЭНХБАЯР				
3. Дарамранз АМГАЛАНБАЯР				
4. Мөнхжаргал ТУЯА				
5. АНДРЕВ Бровн				

Брокер ..... /Гарын үсэг/

/ тэмдэг /

Хувьцаа Эзэмшигч ..... /Гарын үсэг/

2026 он ... сарын ... өдөр

Саналын хуудсын хүчинтэйд тооцон тоолсон Тооллогын Комиссын дарга .....

Комиссын Гишүүн .....

Хүчингүйд тооцсон бол шалтгаан .....

.....

.....

# САНАЛЫН ХУУДСЫГ БӨГЛӨХ САНАМЖ

Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.

## 1. Саналын ердийн аргаар тоолох асуудалд:

- ▶ Тухайн асуудалд зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн аль нэгд нь ✓ эсвэл + тэмдгээр саналаа өгнө.
- ▶ Засварласан, балласан, эсвэл болон аль нэг саналыг бөглөөгүй бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.

## 2. Саналыг кумулятив аргаар тоолох асуудалд:

- ▶ ТУЗ-ийн гишүүдэд санал өгөхдөө кумулятив аргаар санал хураана.
- ▶ Хувьцааны нэгж тутамд ТУЗ-ийн гишүүнийг сонгох 1 саналын эрх байна. Хувьцаа эзэмшигч саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.
- ▶ Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.
  - Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.
  - Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамаарна.



Утас: 7555-1919

И-мэйл: [info@bdsec.mn](mailto:info@bdsec.mn)

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын Өргөн Чөлөө 27/1  
"БиДиСЕК ҮЦК" ХК-ийн байр